



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 013740

Улаанбаатар хот

**Б.Саулед сахилгын шийтгэл  
ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27.4.4, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 37.1.18, 48 дугаар зүйлийн 48.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 1.3.1, 1.5.1, 4.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.1, 10.1, 10.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандаж, Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчиж улсын бүртгэл хөтөлсөн нь Хяналтын улсын байцаагчийн 2020 оны 5070 тоот дүгнэлтээр тогтоогдсон тул Сүхбаатар дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 5 дугаар хорооны улсын бүртгэгч Баймуратын Саулед 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

᠑

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Б.Саулед үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сүхбаатар дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /В.Мөнгөнсүх/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571004475